

МАЛ АЖ АХУЙН САЛБАР ДАХЬ ӨМЧ ХУВЬЧЛАЛ 1990- 1992 ОН: МОНГОЛ ДАХЬ ЭДИЙН ЗАСГИЙН ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

М.Энхбаатар

Товч утга: Монгол орны нийгмийн бүхий л хүрээг хамран өрнөсөн өөрчлөн байгуулалтын нэг салбар нь эдийн засгийн салбар тэр дундаа хөдөө ааж ахуй мал аж ахуйн салбар байсан бөгөөд мал аж ахуйн салбарын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, хурдасгах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр хэд хэдэн арга хэмжээ боловсруулж хэрэгүүлж, шийдвэрлэж байсан юм. Гэвч олон улсын болоод дотоодын нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэн эдийн засгийн салбарт хэд хэдэн төрлийн өмч хувьчлал хийгдсэн. Түүний нэг нь монголын хөдөө аж ахуйн салбарт хийгдсэн мал хувьчлал бөгөөд энэхүү үйл явц өндөр ач холбогдолтой зүйл байсан. Мал хувьчлал нь бусад салбарт болсон өмч хувьчлах үйл явцтай ижил төстэй зүйл ч байсан, мөн өөрийн гэсэн өвөрмөц онцлог дүр төрх ч байсан юм. Гэвч энэхүү мал хувьчлалын үйл явцын уг учир шалтган, нөхцөл байдал, арга зам нь нэн сонирхолтой юм. Түүнийгээ дагаад хүн амын хүлээн авсан хандлага, эдийн засаг нийгмийн нөлөөлөл нь сонирхолтойгоос гадна ач холбогдолтой юм. Мал хувьчлалын үр дүнд 30 гаран жил улс, нийгмийн өмч болоод байсан мал буцааж жинэхэнэ эзэн болсон малчиддаа хүрсэн явдал бөгөөд монгол хүн тэр дундаа малчид өөрийн гэсэн хувийн өмчтэй болсон явдал билээ.

Түлхүүр үг: Мал аж ахуй, Өмч хувьчлал, Өөрчлөн байгуулалт, Перестройка

Оршил

Монгол орны нийгмийн бүхий л хүрээг хамран өрнөсөн өөрчлөн байгуулалтын нэг салбар нь эдийн засгийн салбар тэр дундаа хөдөө ааж ахуй, мал аж ахуйн салбар байсан бөгөөд мал аж ахуйн салбарын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, хурдасгах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр хэд хэдэн арга хэмжээ боловсруулж хэрэгүүлж, шийдвэрлэж байсан юм. Гэвч олон улсын болоод дотоодын нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэн эдийн засгийн салбарт хэд хэдэн төрлийн

өмч хувьчлал хийгдсэн билээ. Түүний нэг нь монголын хөдөө аж ахуй мал аж ахуйн салбарт хийгдсэн мал хувьчлал бөгөөд энэхүү үйл явц өндөр ач холбогдолтой зүйл байсан билээ. Мал хувьчлал нь бусад салбарт болсон өмч хувьчлах үйл явцтай ижил төстэй зүйл ч байсан, мөн өөрийн гэсэн өвөрмөц онцлог дүр төрх ч байсан юм. Гэвч энэхүү мал хувьчлалын үйл явцын уг учир шалтган, нөхцөл байдал, арга зам нь нэн сонирхолтой юм. Түүнийгээ дагаад хүн амын хүлээн авсан хандлага, эдийн засаг нийгмийн нөлөөлөл нь сонирхолтойгоос гадна ач холбогдолтой юм.

Иймд бид мал аж ахуйн салбарт хийгдсэн өмч хувьчлалын түүхийг судлахдаа түүхэн он дарааллын арга аргачлалаас гадна тухайн үеийн нийгэм-эдийн засгийн статистик мэдээ, ард иргэдийн санаа бодлын илэрхийлэл болсон социологийн түүвэр судалгаануудын материал дүгнэлтийг голчлон ашигласанаас гадна Монгол оронд болж өнгөрсөн өмч хувьчлал түүний дотор мал аж ахуйн салбарт хийгдсэн өмч хувьчлалын талаар гадаадын /АНУ, Англи/ улс орнууд, олон улсын байгууллагууд /ДБ, НҮБ/-ын хийсэн судалгаа дүгнэлт тайлан мэдээг түлхүү ашиглалаа. Мөн өөрсдийн цуглуулсан архивын баримт, аман ярилцлагын материалуудыг ч ашиглаж эдгээр нийт баримт материал дээр анализ хийх замаар судалгаа, дүгнэлт хийсэн болно.

Мал аж ахуй бол монгол орны эдийн засаг-нийгэм, соёл ахуйн үндэс болсон гол тулгуур багана нь билээ. Өнгөрсөн XX зуунд Монгол улсад явагдсан нийгэм-эдийн засаг, улс төрийн том том өөрчлөлт шинэчлэл, хувьсгалууд нь монголын эдийн засаг тэр дундаа мал аж ахуйн салбарт гүнзгий ул мөрөө үлдээсэн байдаг.

1. Монгол улсын мал аж ахуйн салбарын хөгжлийн товч түүх

1921 оны ардын ардчилсан хувьсгалын үр дүнд монгол оронд Зөвлөлтийн нөлөөгөөр социализм коммунизмыг байгуулах улс эх орны эдийн засаг, аж ахуйн салбаруудыг төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн арга барилаар удирдан чиглүүлэх зорилт тавигдсан байдаг.

Эдгээр зорилтын нэг нь монгол орны үндэс болсон мал аж ахуйн салбар малчидад чиглэсэн бодлого үйл ажиллагаа байсан юм.

1930-аад оноос малчдыг хүчээр хамтарлжуулах, хамтрал комун байгуулах зэргээр тэр үеийн ЗХУ-д өрнөж байсан бодлого үйл ажиллагааг хүчээр хуулбарлан хэрэгжүүлэх гэсэн оролдлого. 1940-өөд оны үеийн ардын аж ахуйтнуудыг төлөвлөгөөгөөр малыг маллуулах төлөвлөгөөт албан татвараар дарамтлах монгол орны малыг 200 саяд хүргэх популист зорилт тавих зэргээр мал аж ахуйн салбарт чиглэсэн оновчгүй алдаатай бодлого үйл ажиллагаа хэрэгжүүлж байсан юм. Тийм ч учраас дээрх үйл ажиллагаанууд нь зорьсон зорилгодоо хүрж чадалгүй 1950-аад оныг гаргасан байна. Энэ үед мал аж ахуйн салбарын хөгжилд тодорхой ахиц гарсан боловч малчдын

мал маллах эдийн засгийн ашиг сонирхол буурах, малчдын эдийн засгийн чадамж буурах зэрэг байдал бий болсон юм.

1950-аад оны дундуур МАХН хувийн өмчит ардын аж ахуй байгаа нөхцөлд “социализмыг дэлгэрэнгүй байгуулах” боломжгүй бөгөөд түнээс гарах зам бол ардын аж ахуйтныг социалист ёсоор хоршоолох явдал гэж үзсэн байна.¹

Үүний хүрэээнд 1950-аад оны эхнээс хөдөө аж ахуйн нэгдэл байгуулах түүнийг санхүү эдийн хувьд дэмжих ардын аж ахуйтан малчдыг нэгдэлд оруулж малыг нийгэмчлэх талаар олон арван арга хэмжээ явуулсны үр дүнд 1959 онд нэгдэлжих хөдөлгөөн бүрэн яллаа гэсэн дүгнэлтийг хийж Нэгдэлжих хөдөлгөөн ялсан явдлыг Ю. Цэдэнбал МАХН 1921 оны ардын хувьсгал ялсан явдалтай эн дүйцэхүйц үйл явдал² хэмээн үнэлэн дүгнэж байсан билээ.

Хүснэг 1. Нэгдэлжих хөдөлгөөний өрнөлт³

Он	Нэгдлийн тоо	Өрхийн тоо	Гишүүдийн тоо /мян, хүн/	Ардын аж ахуйтанд эзлэх хувийн жин
1940	91		2,0	
1942	106	6300		
1945	99	5662		
1947	106	-	6,3	
1948	111	7225		
1950	139	8250		
1952	165	-	10,0	4,0
1953	173	-	10,2	
1954	187	-	15,4	5,4
1955	239	-	40,7	8,6
1956	565	-	84,6	20,0
1957	638	219,9	119,7	35,0
1958	727	360,1	212,9	33,7
1959	389	-	360,1	72,3
1960	354	-	326,0	

Ийнхүү 1959 оны 4 дүгээр сарын 1 гэхэд албан ёсны баримтаар бол малчин ардууд үйл олноороо сайн дураараа нэгдэлд элссээр 99,7 хувьд хүрчээ.

1. Монгол улсын түүх V боть. УБ., 2004. т. 352.

2. МАХН-ын XIV их хурал. УБ., 1961. т.256.

3. Х. Гүндсамбуу. Монголын нийгмийн давхраажил: хөгжил хандлага XX зуун. УБ., 2002. т.97.

Үнэндээ бол хөдөө аж ахуйн нэгдэлд компаничлан элсүүлээд зогсохгүй, албан татварын бодлогоор шахаж гарцаагүй байдалд оруулсан нь нууц бишээ.⁴

Энгэж монголын малчин ардууд олон зуун жилийн турш эдлэн хэрэглэж гаршуулан өсгөж ирсэн өөрсдийн үндсэн хөрөнгө болсон малаасаа салж үнэн хэрэгтээ улсын малыг маллаж буй хөлсний малчид болон хувирсан юм. Хөдөө аж ахуйн нэгдлийн малыг малласны шанд сард хөдөлмөр өдрийн хөлс гэж авах бөгөөд тэр нь тухайн өрхийн гишүүдийн тоо, маллаж буй малын тоо зэргээс шалтгаалахаас гадна тухайн нэгдлийн эдийн засгийн чадвар чадамж, дарга удирдлагуудын зохион байгуулалт удирдлагаас хамаардаг зүйлс байсан юм. Хөдөө аж ахуйн нэгдлийн зохион байгуулалтаар үндсэндээ сум нэгдэл гэсэн субьектийг нэгтгэсэн бөгөөд хадаа аж ахуйн нэгдлүүд нь дэргэдээ жижгэвтэр үйлдвэр завод сангийн аж ахуйнуудыг байгуулан ажлуулж байсан юм.

Хөдөө аж ахуйн нэгдэлжих хөдөлгөөн ялснаас (малчин ардын дийлэнх олонх нэгдэлд элссэнээр) хойш хөдөө аж ахуйн мал аж ахуйн салбарт гарч байсан амжилт ололт, үр ашиг бүхий зүйлс олон байсан боловч улс, төр, эдийн засгийн олон хүчин зүйлсээс хамааран нийтээрээ ашигтай ажиллаж чадахгүй улсын их хэмжээний татаас дэмжлэгтэйгээр л ажиллаж оршин тогтнож байлаа.

Энэ үеийн нэгдлийн малчин ардын амьдралын хэв маяг: Малчин өрх айл дунджаар нэгдлийн 400-600 гаруй толгой малыг хариулдаг боловч аминдаа говь хангайн бүсийн ялгаагаар 50-75 толгойгоос илүү малтай байхыг зөвшөөрдөггүй байв. Тэдний амьдралын үндсэн эх сурвалж нь нэгдлийн мал хариулсаны хөлс, мах, ноос, ноолуур гэх мэт түүхий эд бэлтгэснээс орох орлогоос бүрдэж байв. Бүс нутгийн онцлог, ХААН-н нэгдлийн хүчин чадлаас хамааран ялгаатай байсан хэдий ч нэг малчин сард дунджаар 250-400 төгрөгийн хөдөлмөр өдрийн хөлс авдаг байжээ. Социализмын үеийн малчид бүрэлдэхүүний хувьд хоньчин, ямаачин, адуучин гэх мэт мэргэжлийн гэж болох бүлгээс тогтож байсан нь мал аж ахуйн хөдөлмөр зохион байгуулалттай холбоотой. Эдгээр нь маллагааны өвөрмөц арга барил шаарддаг боловч малчны мэргэжлээс онцгой ялгарч байсан гэхэд хэцүү. Малчдын эгнээг ерөнхий боловсрол төгссөн залуучуудаар өргөтгөх зохион байгуулалттай арга хэмжээ авч явуулсан нь тэдний бүрэлдэхүүнд дэвшилтэт өөрчлөлт гаргасан юм. Бүрэлдэхүүний энэ өөрчлөлттэй холбоотойгоор аж ахуйгаа хөтлөх, чөлөөт цагаа өнгөрүүлэх, ажил хөдөлмөрөө сонирхох үнэлэх талаар малчдын уламжлалт байдал шинэчлэгдэж эдгээр асуудалтай холбогдсон шүүмжлэлт уур амьсгал өрнөх болов.

4. Х. Гүндсамбуу. Монголын нийгмийн давхраажил: хөгжил хандлага XX зуун. УБ., 2002.т.97.

Өөрөөр хэлбэл залуу малчдын нийгмийн асуудал хүчтэй дэвшигдэхдээ малчдын амьдралын түвшин, хөдөлмөрийн хөлсний үнэлгээ, амины малын тоон хязгаарлал, хөдөө дэх соёл ахуйн орчны тухай асуудлыг басхүү хөндсөн хэрэг байлаа.⁵

Хүнс хөдөө аж ахуйн хөгжлийн тулгамдсан асуудлыг МАХН-ын Төв Хороо хэлэлцэн шийдвэрлэж байв. Тухайлбал хөдөө аж ахуйн нэгдлүүдийн зохион байгуулалт, эрх зүйн үндсийг боловсронгуй болгох /1967/, Малыг дулаан, хашаа саравчаар хангах, тэжээл бэлтгэх /1968/, Мал аж ахуйн тогтвортой өсөлтийг нэмэгдүүлэх, материаллаг баазыг нь бэхжүүлэх /1971/, Хөдөөгийн барилгын ажлыг сайжруулах /1973/, Махны нөөцийг нэмэгдүүлэх /1976/, Хөдөө аж ахуйн удирдлагын эдийн засгийн аргыг нэвтрүүлэх /1987, 1988/, зэрэг асуудлыг тусгайлан хэлэлцэж байв. Хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд зориулах хөрөнгө оруулалтыг төлөвлөгөөт таван жил тутамд нэмэгдүүлж байв. Тухайлбал 1971-1980 онд энэ салбарыг хөгжүүлэхэд өмнөх арван жилийхээс хоёр дахин их хөрөнгө оруулсан байна. Дараагийн таван жилүүдэд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэхэд оруулах хөрөнгө оруулалтыг 30 шахам хувиар нэмэгдүүлсэн байдаг.⁶

Үүний үр дүнд хөдөө аж ахуйн нэг нэгдэлд 1986 оны байдлаар дунджаар 4881,8 мянган төгрөг, 432 мянган га хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 12 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, нийгмийн 60,9 мянган мал, 44 трактор /15 морины хүчинд шилжүүлснээр/, 14 автомашин ноогдож байв.⁷

2. Мал аж ахуйн салбар дахь өөрчлөн байгуулалт

Монголоронд өрнөсөн өөрчлөн байгуулалтын жилүүдэд улс эх орны бүхий л салбарт байгаа асуудлыг шийдвэрлэх тэр дундаа хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарт байгаа асуудлыг шийдвэрлэх өөрчлөлт шинэчлэлт хийх талаар олон арга хэмжээ авч байсан бөгөөд түүний нэг нь ЗСБНХУ-аас туршлага болон олж ирсэн Гэрээ түрээсийн арга билээ. Гэрээ түрээсийн арга гэдэг нь нэгдлийн малыг нэгдлийн малчинд гэрээ байгуулж түрээслүүлэх байдлаар маллуулах арга бөгөөд тухайлбал 100 хонь гэрээгээр малчинд түрээсээр маллуулаад жилийн дараа 115 хонь болгож авна. Илүү гарсан хонийг тухайн малчинд өгөх байдлаар нэгдэлд ч ашигтай, мал маллаж байгаа малчинд ч ашигтай байх буюу малчдын мал маллаж мал өсгөх сонирхлыг дээшлүүлж нэмэгдүүлэх зорилго бүхий арга билээ. Гэрээ түрээсийн аргыг анхлан 1988 онд Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын сум-нэгдлийн дарга Хөдөлмөрийн баатар С. Аварзэд анхлан нэвтрүүлсэн бөгөөд 1990 он хүртлэх хугацаанд нэлээн хэдэн хөдөө аж ахуйн нэгдлүүд энэхүү арга туршлагыг нэвтрүүлж

5. Нийгмийн шинэчлэл: амьдралын хэв маягийн өөрчлөлт. УБ., 2001. 153 тал.

6. Монгол улсын түүх V боть. УБ., 2004. т.381.

7. Монгол улсын түүх V боть. УБ., 2004. т.383.

тодорхой хэмжээний ололт амжилтууд олж эхлэж байсан юм.

Гэвч хөдөө аж ахуйн нэгдлүүдийг хөгжүүлэх, бэхжүүлэх нэрийдлээр тодорхой бодлогогүй нарийн тооцоогүй их хэмжээний хөрөнгийг улсын сангаас оруулж, гарсан алдагдлыг тухай бүрд нь нөхөж байсан боловч, эцсийн бүтээгдэхүүний хувьд тууштай өсөж чадаагүй байна. Мал сүргийн зохистой бүтэц алдагдаж, нөхөн үйлдвэрлэлд сөрөг нөлөө үзүүлжээ. 1990 оны байдлаар хөдөө аж ахуйн 255 нэгдлийн 105 нь өрөнд баригдсан тэдний 60 шахам хувь нь ойрын жилүүдэд өрнөөс гарах боломжгүй болсон байв.⁸ Мөн ХАА-н нэгдэлд ажиллах мэргэжилтэй боловсон хүчин хүрэлцээгүй, хөдөө мал дээр гарч мал маллах залуу малчдын залгамж халаа үгүй болсноос өндөр настай малчид давамгайлах болж нэг малчинд оногдох малын тоо толгой их байх болж ажиллах боловсон хүчин зохион байгуулалтын хувьд ч доголтой болсон байдаг.

Ийнхүү 1989 оны сүүлч 1990-ээд оны эх болоход олон улсын нөхцөл байдал, БНМАУ-ын дотоодын улс төрийн нөхцөл байдлаас үүдэн ардчилсан хөдөлгөөн өрнөн жагсаал цуглаан зохион байгуулж эрх баригч МАХН-д эрс шийдэмгий шинэчлэл өөрчлөлт хийх, улмаар УТТ-г огцрох шаардлага тавьсан бөгөөд 1990 оны 03 сарын 10-ны өдөр МАХН-ын УТТ бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорч улс төрийн удирдлага өөрчлөгдөж улмаар БНМАУ-ын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан билээ.

3. Мал аж ахуйн салбар дах өмч хувьчлал

Шилжилтийн эхэн үеийн төрийн бодлого, засгийн газрын хөтөлбөрийн зах зээлд шилжих зарчим, зорилт, арга хэмжээний ерөнхий үндэс нь “Зах зээлийн эдийн засагт шилжихтэй холбогдсон асуудлаар МАХН-ын баримтлах байр суурь” хэмээх баримт бичиг болсон бөгөөд харин өмч хувьчлах арга замын талаар баримтлах бодлогын гол үндэс нь Монголын Үндэсний Дэвшлийн намын үзэл баримтлал болсон гэж үзэж болно. Үүний зэрэгцээ зах зээлийн эдийн засагт шилжих цогцолбор үйл явцыг хэрэгжүүлэхэд тэр үеийн улс төрийн намуудын үзэл баримтлал, гадаад, дотоодын эрдэмтэн мэргэжилтнүүдийн судалгаа, дүгнэлт чухал ач холбогдолтой байсан билээ.⁹

Өмч хувьчлал бол:

1. Орлогын урсгалд өөрчлөлт бий болгодог үндсэн дээр хийгддэг хөрөнгийн дахин хувиарлалт юм.

2. Өмч эзэмшигчдийн хувьд гарч буй өөрчлөлт нь хуучин улсын эзэмшилд байсан өмчлөлийн зорилго, хариуцлагыг өөрчилнө.

3. Өмч хувьчлал нь улсын төсвийн бүтэц, улсаас үзүүлж байсан нийгмийн болон бусад үйлчилгээнүүдийн хариуцлага чадвахид өөрчлөлт оруулна.¹⁰

8. МАХН-ын Оц их хурал. УБ., 1990. т.10.

9. Монгол улсын түүх V боть. УБ., 2004. т.491.

10. Фредерик Никсон, Бернард Волтерс. Хувьчлал, Орлогын хувиарлалт, Ядуурал: Монгол улсын туршлагаас. УБ., 2004. т.5.

1990-1991 онд Монгол оронд өрнөж байсан өөрчлөн байгуулалт, эдийн засаг, улс төрийн огцом огцом хувирал, шинэчлэлтүүдтэй холбоотойгоор тухайн үед Монгол улсын ШУА-ийн Философи, Социологи эрхийн хүрээлэнгээс ард иргэдийн дунд социологийн санал асуулгын судалгаа хийж байсан бөгөөд тэдгээр судалгаанууд дотор өмч хувьчлалтай холбоотой асуудлууд байна.

Тухайлбал 1991 оны 04 сарын 3-15-ны хооронд Улаанбаатар, Дархан, Хэнтий, Өмнөговь, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн 12 сумаас янз бүрийн насны, төрөл бүрийн ажил мэргэжилтэй 100 гаруй байгууллагын 1300 хүнийг төлөөлүүлэн авсан социологийн судалгаагаар: Өмч хувьчлах үйл явцыг үнэлж байгаа үзэл бодлоор нь хүн амыг 3 үндсэн бүлэгт хуваан үзэж болно.

1. Энэ үйл явцыг даруйхан хэрэгжүүлж эхлэх хэрэгтэй гэж үзэж байгаа хэсэг бүлэг /16,4%/ энэ бүлгийхний гол цөм нь захиргаа-удирдлагын сэхээтэн, инженер, техникийн ба бага тушаалын гүйцэтгэх ажилтнууд болон эрхэлсэн ажилгүй хүмүүс.

2. Өмч хувьчлах нь нухацтай бодож шийдэх ёстой асуудал учир нэг их яарах хэрэггүй гэж үзэгсэд /49,3%/ энэ бүлгийхний гол цөм нь цэрэг, цагдаа оюутнууд болон бүтээлч-сэхээтэн, захиргаа-удирдлага, инженер техникийн ажилтнууд юм.

3. Ерөөсөө улсын өмчийг хувьчлан задлаж болохгүй гэж үзэгсэд /11,9%/ эд нар голлон тэтгэвэрт байгаа хүмүүс, малчид, ажилчдаас бүрдэнэ. Тэд гол төлөв ХАА-н нэгдэл, улсын байгууллагуудад ажиллагсад юм.

Мөн өмч хувьчлах үйл явцын учир холбогдлыг ойлгоогүй байгаа хүмүүс бас байсан бөгөөд /21,0%/ эд голдуу малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгсэд, ажилчдын дунд байна. Тэр дундаа судалгаа оролцсон нийт малчдын /44,1% тухайн үед ямар нэгэн ойлголтгүй байсан байна.¹¹

Эндээс харвал өмч хувьчлалын тухай хууль батлагдаж өмч хувьчлах, малч хувьчлах ажил эхлэхийн өмнөхөн үед ард иргэд өмч хувьчлах асуудлыг нухацтай авч үзэх хэрэгтэй, яарах хэрэггүй гэж үзэж байсны зэрэгцээ ХАА-н нэгдэл, малчдын дийлэнх олонхи нь өмч хувьчлалын талаар ямар нэгэн ойлголтгүй байжээ.

Үүний зэрэгцээ өмч хувьчлалыг хэрхэн ямар аргаар явуулах, өмчлөлийн хэлбэрээс хамаарсан ялгаа байх ёстой эсэх дээр ч янз янзын санаа бодолтой байжээ. Өмч хувьчлахад түрээсийн аргыг хэрэглэх нь зүйтэй /52,5%/, шууд хувьд өгөх /13,5%/, худалдах буюу зээлээр өгөх /6,6%-ыг тус тус дэмжих байсан бөгөөд 1990 оны сүүл 1991 оны эхээр нэгдлийн дарга нарын дунд явуулсан захидал судалгаанд хамрагсдын 60,1% нь нэгдлийн өмчийг задлах нь зүйтэй, 67,3% нь түрээсийн аргыг илүүд үзэж байжээ.¹²

11. Улс орны амьдрал олон түмний санаа бодолд. /Социологийн цуврал судалгааны тайлангийн эмхэтгэл/ УБ., 2007. 19 тал.

12. Улс орны амьдрал олон түмний санаа бодолд. /Социологийн цуврал судалгааны тайлангийн эмхэтгэл/ УБ., 2007. 22 тал.

Ийм нөхцөл байдалд өмч хувьчлалыг яаралтай цочмог эмчилгээний аргаар хийж хэрэгжүүлэхэд олон хүчин зүйл нөлөөлсөн бололтой байдаг. Тэдгээрийн дотор 1990 оноос Монгол улсад эдийн засгийн чиглэлээр бодлогын зөвлөгөө өгч байсан гадны эрдэмтэн мэргэжилтэнгүүдийн санал зөвлөгөө голлох нөлөөтэй байсан байдаг. Мөн 1990 оноос манай улсын ДНБ-ын 30%, гадаад худалдааны нийт эргэлтийн дийлэнх хувийг эзлэж байсан ЗСБНХУ нь дотооддоо эдийн засаг, улс төрийн хүнд байдалд орж улмаар 1990 оноос гадаад улс орнуудад үзүүлж байсан эдийн тусламж дэмжлэг, зээлийн асуудлыг зогсоож БНМАУ-тай хийж байсан гадаад худалдаан дээр хориг саад тавих болсон. Мөн ЗСБНХУ-ын дараа орох ЭЗХТЗ тарж монгол орны эдийн засгийг хөдөлгөж байсан гадаад эх үүсвэрүүд үгүй болсноор нийгэм-эдийн засгийн байдал дотооддоо маш их хүндэрч эхэлсэн.

БНМАУ-ын Засгийн газраас 1991 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 251 дүгээр тогтоол гаргаж, “Өргөн хувьчлалын тухай”¹³ БНМАУ-ын хууль”-ийн төслийг Улсын бага хуралд өргөн барьж байжээ. Тэрхүү төслийг аж ахуйн нийгэмлэгийн тухай хуультай багц болгон хэлэлцэх шаардлагатай уялдуулан Өмч хувчлалын тухай хуулийн төслийг 1991 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр дахин өргөн барьсан байна. Ийнхүү 1991 оны 5 дугаар сарын 22-ны өдөр БНМАУ-ын өмч хувьчлах тухай хууль батлагдсан түүхтэй. Өмч хувьчлалын тухай хуулийн 1-р зүйлд зааснаар Энэхүү хуулийн зорилт нь Монгол Улсын төрийн өмчид байгаа эд хөрөнгийн тодорхой хэсгийг Монгол Улсын иргэд болон энэ хуульд заасан хуулийн этгээдийн өмчид шилжүүлэх /цаашид “хувьчлах” гэх/-тэй холбогдсон харилцааг зохицуулах, түүнчлэн хөдөө аж ахуйн нэгдлийн өмчийг хувьчлах зарчмын онцлогийг тодорхойлоход оршино¹⁴ гэж заасан.

1991 оны 5 сар гэхэд “Өмч хувьчлалын тухай”, “Аж ахуйн нэгжийн тухай”, “Банкны тухай”, “Татвар, гаалийн тухай”, “Аж ахуйн нэгжийн дампуурлын тухай” хуулиуд гарч төрийн өмчийг хувьчлах болон хувьчилсны дараах аж ахуйн харилцааг зохицуулах хууль эрх зүйн орчин бүрэлдэж эхэлсэн байна. Ялангуяа “Өмч хувьчлах тухай хууль”-тай “Аж ахуйн нэгжийн тухай хууль”-ийг хамтад нь боловсруулан гаргасны үр дүнд хувьчлал явуулах арга хэлбэрийг тогтоох, хувьчилсны дараах үйл ажиллагаагаа зах зээлийн дэг жаягаар хөтлөн явуулах бололцоог бий болгосон байна.

Монгол улсад өмч хувьчлал нь дараах үндсэн хэлбэртэй хийгдсэн.

1. БНМАУ-ын Өмч хувьчлалын тухай хуулийн 3-р бүлэг: Үйлдвэрийн газрын эд хөрөнгийг хувийн өмчид шилжүүлэх /Бага хувьчлал/

2. БНМАУ-ын Өмч хувьчлалын тухай хуулийн 4-р бүлэг: Үйлдвэрийн газрын эд хөрөнгийг хувьцаалж хувийн өмчид шилжүүлэх /Их хувьчлал/

13. УИХ-ын архивт Өмч хувьчлах тухай хуулийн хувийн хэрэг нь анхны төсөл болох ергөн хувьчлалын тухай гэсэн нэрээрээ хадгалагдаж байна.

14. БНМАУ-ын Өмч хувьчлалын тухай хууль. УБ., 1991.

3. БНМАУ-ын Өмч хувьчлалын тухай хуулийн 5-р бүлэг: Хөдөө аж ахуйн нэгдлийн өмч хувьчлах гэсэн үндсэн хэлбэртэй явагдсан.

Ийнхүү хөдөө аж ахуйн нэгдлүүдийг хувьчлах хууль эрх зүйн үндэс тавигдсан бөгөөд БНМАУ-ын Өмч хувьчлалын тухай хуулийн 21-р зүйлд Хөдөө аж ахуйн нэгдлийн өмчийг хувьчлах ерөнхий зарчмыг:

1. Хөдөө аж ахуйн нэгдлийн өмчийг энэ хууль, Монгол Улсын Аж ахуйн нэгжийн тухай хууль болон бусад хуульд нийцүүлэн тухайн нэгдлийн бүх гишүүний саналыг үндэслэн хувьчилна. Хувьчлах аргаа тухайн нэгдлийн гишүүд өөрсдөө сонгоно. Энэ ажилд Монгол Улсын Засгийн газраас арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ.

2. Нэгдлийн гишүүдэд олгосон эрхийн бичиг нь юуны өмнө тухайн нэгдлийн үндсэн хөрөнгөөр баталгаажина. Нэгдлийн гишүүн өрхийн нэгдэлд элсээгүй гишүүнд олгосон эрхийн бичиг нь төрийн өмчөөр баталгаажина. Хэрэв тухайн нэгдэл өрхийнхээ нэгдэлд элсээгүй гишүүнд эрхийн бичгийн нэрлэсэн үнийн хэмжээгээр өмч хувьчлан шилжүүлсэн бол төрийн өмчөөс эд хөрөнгө давхардуулан хувьчлахгүй. Энэ заалт нэгдлийн гишүүн, уул өрхийн нэгдлийн гишүүн бус иргэдийн төрийн өмчөөс хувьчлах эд хөрөнгө, хувьцаа худалдан авах эрхийг хөндөхгүй гэж тус тус заасан.

Ийнхүү Өмч хувьчлалын тухай хуулийг дагалдан Өмч хувьчлалыг зохион байгуулах засгийн газрын журам батлагдсан бөгөөд өмч хувьчлал тэр дундаа мал аж ахуйн салбар дахь өмч хувьчлал нь дээрх эрх зүйн хүрээнд харьцангуй богино хугацаанд зохион байгуулагдсан билээ.

Нэгдлийн гишүүдэд хувьчлахдаа:

1. Зөвхөн тухайн нэгдлийн малыг маллаж буй малчин нэгдлийн гишүүдэд
2. Сум, нэгдлийн төвийн албан хаагчид, малчдын гэр бүлийхэнд
3. Нэгдлийн малчид албан хаагчдадаас гадна анх нэгдэлд малаа нийгэмчилсэн иргэдэд гэсэн байдлаар явуулсан байна.

Энэ хэлбэрийг болоод хувиарлалтыг тухайн үед болоод өнөөдөр ч шудрага бус хувиарлалт болсон гэж үздэг бөгөөд зарим тохиолдолд мал хувьчиллаас өмч хувьчилж авах эрхтэй, гавьяатай хүмүүс юу ч үгүй хоцорсон тохиолдол ч байгаа билээ. Үүнд ихэвчлэн тухайн үеийн тэтгэвэрийн насныхан, цөөн ам бүлтэй гэр бүлүүд хохирох нь элбэг байжээ.

1991-1993 оны хооронд Хөдөө аж ахуйн нэгдлийн хувьчлалд 267 нэгдэл, тэдгээрийн дундын 20 гаруй аж ахуйн нэгжийг хамруулахаар төлөвлөж тухайн үеийн үнээр тэрбум гаруй төгрөгийн хөрөнгийг ХОЭБ-ийн цэнхэр тасалбараар, 1.9 тэрбум төгрөгийн хөрөнгийг ХОЭБ-ийн ягаан тасалбараар нэгдлийн гишүүдэд нь хувьчилсан байна. Нэгдлийн гишүүд тэдгээрийн гэр бүл болон сумын зарим албан хаагчид 3,6 сая малыг үнэ төлбөргүй хувьчилж авсан байна.

Хувьчлалын үр дүнд 1992 он гэхэд өрхийн яг 5 хувь нь 200-аас дээш толгой малтай болсон байсан ба хувиарлалтын төгсгөлд нийт өрхийн 42 хувь нь 31-ээс доош толгой малтай байсан. Гэтэл 2000 онд нийт өрхийн 63 хувь нь 100-аас доош толгой малтай, 22 хувь нь 100-200 толгой малтай, 12 хувь нь 200-500 толгой малтай байсан гэсэн тооцоо гарчээ. □ Энэ нь анхны хувирлалт тэгш бус байснаас гадна цөөн тооны мал авсан зарим өрхүүд олон малтай байх нь хэцүү гэж үзэх, малчдын мал маллах ур чадвар янз бүр байсан, зарим залуу туршлагагүй малчид байгалийн гамшиг болон ур чадваргүйгээсээ болж малаа алдсан байдаг. Зарим нь эдийн засгийн хүнд үед амьжиргаагаа залгуулахын тулд малаа зарж хэргэлсэн байдаг. Харин зарим өрхүүд малынхаа тоог нэмэгдүүлж амжилттай ажиллаж амьдарсан нь ч бий.

Ийнхүү тэгш бус байдал үүсэхэд мал хувьчлахын хамт нэгдэл-үйлдвэрийн газрууд задарсан явдал ч нөлөөлсөн. “Малын эмчийн үйлчилгээ, мал усалдаг худгийн засвар үйлчилгээ болон мал аж ахуйн бүтээгдэхүүнийг дэмждэг улсын бусад дэмжлэгийн хэмжээ багассан. Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны судалгаа, мал маллах олон арван жилийн туршлагын ололт амжилт орхигдож эхэлсэн. Хөдөөгийн зах зээл уналтанд орж, арилжааны эдийн засаг, малын арилжаанд хүргэсэн. Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ суларсан. Улс бэлчээрийн эрсдлийн удирдлага, ялангуяа өвс тэжээл үйлдвэрлэдэг хуучин татаасын хариугүй уналтанд орох гэж байгаа системээс өвс тэжээлээр хангах, малын заавал даатгал зэргээс ухралт хийсэн.

1991-1993 онд болсон мал хувьчлал, хөдөө аж ахуйн нэгдэл хоршоодын задралын талаар тухайн үед ард иргэд хэрхэн үзэж ойлгож, дүгнэж байсан талаар ШУА-ийн Философи, социологи эрхийн хүрээлэнгийн 1992 оны 5 дугаар сарын 6-16 нд Улаанбаатар хот, Өвөрхангай, Өмнөговь, Ховд, Хэнтий аймгийн 12 сумын 100 гаруй байгууллагын 1180 хүн оролцсон судалгаагааны дүнг харвал. Судалгаанд оролцогчдын 70,4% нь өмч хувьчлалыг хэрэгжүүлж байгаа арга зам, үр дүнд нь сэтгэл дундуур байгаагаа илэрхийлж, 26,4% нь одоо хүртэл надад өмч хувьчлалын талаар мэдэх юм алга гэж хариулжээ. □ Энэ бол өмч хувьчлал явагдаж байх үеийн ард иргэдийн ойлголт, дүгнэлтийн нэг тусгал юм.

Хөдөө аж ахуйн нэгдлийн өмчийг хувьчлах явцад гарсан нэг зүйл хөдөө аж ахуйн нэгдлүүдийн өмч, үйлдвэрийн газруудын тоног төхөөрөмж эд хогшлыг малын адил хувьд шилжүүлсэн бөгөөд ихэнх тохиолдолд нэгдлийн гишүүд болоод өмч хувьчлалд оролцох эрх бүхий иргэдэд тэгшитгэн тараасан билээ. Гэвч иргэд нэг оёдлын машин, нэг трактор гэх мэт янз бүрийн тоног төхөөрөмж эд хөрөнгөтэй болсон. Гэвч хувьчлалын дараа тэрхүү хувьчилж авсан эд хөрөнгө тоног төхөөрөмжөө үр бүтээлтэйгээр ашиглах байдал туйлын хангалтгүй байж ихэнх тохиолдолд үрэн таран болох эс бөгөөс маш

хямд үнээр зарж борлуулсан байдаг. Энэ нь хөдөө аж ахуйн нэгдлийн үед ажилаж тодорхой хэмжээний үйл ажиллагаа явуулж байсан үйлдвэрүүд дахин сэргэхгүйгээр устаж үгүй болох нөхцөл болсон билээ.

Зарим хөдөө аж ахуйн нэгдлүүд хувьчлалын дараагаар хувьцаат компаний хэлбэрээр ажиллах оролдлогууд хийж байсан боловч үр дүнд хүрсэн нь тун ховор бөгөөд ихэвчлэн байгуулагдснаас хойш тун удалгүй дампууран үүд хаалгаа барьцгаасан.

Ийнхүү 1991-1993 оны хооронд монгол оронд өрнөсөн өөрчлөлт, ардчилсан шинэчлэлийн үр дүнд зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих, улсын өмчийг задлаж хувьчлах замаар ард иргэдээ өмчтэй болгох, хувийн секторыг хөгжүүлэх замаар улсад ирж байсан эдийн засгийн ачааллаас салах, эргээд эдийн засагтаа дэмжлэг, өсөлт бий болгох гэсэн өмч хувьчлалын нэг хэсэг болсон мал аж ахуйн салбарт хийгдсэн хувьчлал маш богино хугацаанд мал аж ахуйн салбарыг 100% хамран хийгджээ.

Мал аж ахуйн салбарын өмч хувьчлал болсноор дээр дурдсан сөрөг үр дагаварууд гарснаас гадна нийт малын тоо толгой 1991 онд 25,5 сая¹⁵ байсан бол 1999 он гэхэд 33,5 сая¹⁶ болсон байдаг. Мөн мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ нэмэгдэж малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнээс олох малчдын орлого өссөн. Гэвч энэ нь тухайн өрхийн малын тоо, малчны арга ухаанаас хамаарах зүйл гэдгийг анхаарах хэрэгтэй. Мөн зарим нэр төрлийн тухайлбал ноолуурын зах зээл дэх эрэлт өсөж үнэ нэмэгдснээс нийт малын бүтцийн зохистой харьцаа алдагдах байдал гарч эхэлсэн.

Дүгнэлт

Эцэст нь дүгнэхэд, Монгол орон социализмын замаар хөгжиж нийгэм журамт нийгмийг байгуулах зорилгоор малыг өмчийг эздээс нь салган нийгэмчлэх буюу хоршоолох замаар хөдөө аж ахуйн нэгдлүүдийг бий болгожээ. Гэвч улсын өмч болохын хувьд мал аж ахуйн салбарыг хөгжүүлж малын тоо толгойг өсгөх, мал аж ахуйн салбараас олох ашгийг нэмэгдүүлэх гэж удаа дараа янз бүрийн түвшинд зорилтууд тавьж байсан боловч төдийлөн амжилтанд хүрэлгүй гарч байсан ахиц нь зарцуулж байсан зарлага, хөдөлмөрөөсөө илүү гарч чадахгүй байсан бололтой байна. Үүнээс үүдэн улсаас асар их хэмжээний татаас өгөх нөхцөл үүсч хөдөө аж ахуйн нэгдлүүдийн зарим нь өрөнд баригдаж үйл ажиллагаагаа явуулах чадваргүй болох нөхцөл байдалтайгаар 1990 онд хүрчээ.

Мал аж ахуйн салбарт хийгдсэн өмч хувьчлал нь өмч хувьчлалын нэг болохын хамт эдийн засаг нийгмийн салбарт хийгдсэн бусад бүтцийн өөрчлөлт шинэчлэлтүүдийн нэг хэсэг юм. Иймдээ ч зарим утгаараа энэхүү

15. УСХ 1991 оны Монгол улсын статистикийн тайлан эмхэтгэл УБ., 1991.

16. УСХ 1999 оны Монгол улсын статистикийн тайлан эмхэтгэл. УБ., 1999.

өмч хувьчлал нь засгийн газраас гаргасан улс төрийн шийдвэр байжээ. Өмч хувьчлал нь эдийн засгийн хүнд нөхцөл байдалд явагдсан. Үүний зэрэгцээ үйлдвэр аж ахуйн газрууд хөдөө аж ахуйн нэгдлүүдийг хувьчлах талаар тухайн үеийн ард иргэдийн санаа бодлыг төдийлөн харгалзаж үзэлгүй шийдвэр гаргаж хэрэгжүүлсэн байна. Тухайн үед нийт ард иргэдийн 80 гаруй хувь нь өмч хувьчлалын эсрэг буюу өмч хувьчлалын талаар ойлголтгүй байсан байна. Энэ нь ч өмч хувьчлалын үр дүнд сөргөөр нөлөөлсөн хүчин зүйлсүүдийн нэг болжээ.

Улсын өмчийг тэр дундаа хоршоолсон өмч болох мал аж ахуйг хувьчлах арга замыг сонгохдоо үндсэнд нь эрхийн бичиг буюу ваучерийн аргыг сонгосон боловч түүний явц, хэрэгжилтэд улсаас төдийлөн анхаарч хяналт тавиагүй байдал ажиглагдаж байна. Анх малын нийгэмчлэн өмчийн хувьд тэгшитгэх гэсний адилаар мөн хувьчлахдаа эргээд тэгш хувийн өмчтэй болгох гэж оролдсон байна. Гэвч энэ нь мөн л амжилт ололгүй сөрөг үр дагаваруудыг олноор бий болгожээ.

Мөн мал аж ахуйн салбарт хийгдсэн өмч хувьчлал нь хэт түргэн хийгдсэн бөгөөд тийм ч ил тод болсонгүй. Хамгийн гол нь тэртээ тэргүй хүнд нөхцөлтэй байсан мал аж ахуйн салбарыг хувьчлахдаа жаахан ч гэсэн дэм болж байсан улсын дэмжлэг улсын болон хоршооллын байгууллагуудыг хамтад нь хувьчилж, хувьчилахдаа тусгайлан анхаараагүйгээс эргээд хувьд гарсан мал аж ахуйд хүнд цохилт болжээ.

Дээрхээс үүдэн мал аж ахуйн салбарт өмч хувьчлал (бусад салбарых ч мөн адил) нь тэгш бус байдлыг бий болгож түүнийгээ дагаад ажилгүйдэл, ядуурлын нөхцөл байдал огцом өсөхөд хүргэжээ.

Түрүүнд дурдсанчлан мал аж ахуйн салбарын өмч хувьчлал нь бусад салбарт хийгдсэн өмч хувьчлалын нэг хэсэг тул бусад салбарт хийгдсэн өмч хувьчлалын үр дүн, мал аж ахуйн салбарын өмч хувьчлалын үр дүнд нөлөөлөхөөс гадна эргээд бусад салбарын өмч хувьчлалын үр дүнд ч нөлөөлж байсан нь гарцаагүй.

Ийнхүү нийт өмч хувьчлал болоод тухайн үеийн эдийн засаг, нийгмийн бусад нөхцөл байдалтай холбоотойгоор Монгол улсын эдийн засгийн нөхцөл байдал ямар байсан нь дараах хүснэгтээс харагдаж байна.

Хүснэг 2. Бодит ДНБ ба эдийн засгийн өсөлтийн хэмжээ¹⁷

д/д	1989	1990	1991	1992	1993	1994
ДНБ	651,5 сая	635,1 сая	576,4 сая	521,6 сая	505,9 сая	517,6 сая
Өсөлт	4,2 %	-2,5%	-9,2 %	-9,5 %	-3,0 %	2,3 %

17. ОУВС-ийн тайлан. УБ., 2002. 7 тал.

Ийнхүү шилжилтийн эхэн үед эдийн засгийн хүрээнд хийсэн өөрчлөлт буюу өмч хувьчлал нь төдийлөн зорьсон үр дүндээ хүрээгүй байдал ажиглагдаж байна. Үүнээс ч үүдэн өнөөдрийг хүртэл ард иргэдийн дунд өмч хувьчлалын талаар сөрөг таагүй дүгнэлт дурсамжууд байсаар байна. Энэхүү таагүй сөрөг дурсамж дүгнэлтүүд нь Улаанбаатар, Ховд, Увс, Булган зэрэг аймгуудад хийсэн аман ярилцлагын дүнд ч харагдаж байна. Ярилцлага өгсөн янз бүрийн нас, хүйс, ажил мэргэжил бүхий иргэд бүгд л өмч хувьчлалаас юм хүртэж чадаагүй, үр дүнгүй буруу зүйл болсон гэсэн дүгнэлтүүд хэлж байлаа.

Гэвч шилжилтийн хүнд үеүүдийн даван монгол улсын улс төр, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал тогтворжихийн хэрээр мал аж ахуйн салбарын хувьчлалын үр дүнд монгол улсын малын тоо толгой өсч урд өмнө байгаагүй өндөр хэмжээнд 2012 оны эцийн байдлаар 50 сая¹⁸ толгойд хүрээд байгаагийн зэрэгцээ малын гаралтай түүхий эдийн зах зээлийн ханш өсөж түүнээс олох малчдын орлого жилээс жилд өсч байна.

Abstract: “Perestroika” in Mongolia has involved all social spheres, particularly the agriculture and cattle-breeding sector. In order to provide and intensify the economic growth and increase a profitability of cattle-breeding, the number of measures has been implemented. However, due to social, political and economic circumstances, the privatization of the cattle has been preceded specifically. As a result of cattle privatization, the cattle, belonged before to state during the period for more than three decades, was given back to its real lords, the herders. This had a far going importance, the Mongolian herders, have got an opportunity to possess a private property.

18. УСХ 2012 оны Монгол улсын эдийн засгийн тайлан эмхэтгэл. УБ., 2012.